

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮДЭД

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны 15 дугаар тэмдэглэлд:

“ХХИХ.3. “Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн 2017 оны жилийн эцсийн дүнг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав.

Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч ажиллахыг сайд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав:

1. Улсын Их Хурал болон Байнгын хорооны тогтоол, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр, Засгийн газрын шийдвэрээр Засгийн газар, сайд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасан заалт бүрийг хяналтад авч, хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах;

2. 2017 оны жилийн эцсийн байдлаар хангалтгүй үнэлэгдсэн, тасарсан болон хэрэгжилт нь удааширч байгаа үүрэг, даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэхэд анхаарч ажиллах;

3. Хэрэгжилт тогтмолжсон, бүрэн хэрэгжсэн, цаг үеийн шинжтэй гарсан шийдвэр, заалтыг тухай бүр нь хяналтаас хасуулж хэвших;

4. Хууль тогтоомжид заасан эрх зүйн акт (дүрэм, журам, заавар, бусад)-ыг хугацаанд нь баталж мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;

5. Монгол Улсын Засгийн газраас 2018 оныг сахилга, хариуцлагыг сайжруулах жил болгон зарласантай холбогдуулан Ерөнхий сайдын 2017 оны 01 дүгээр Албан даалгаврын хэрэгжилтийг эрчимжүүлж, үр дүн, үр нөлөөг бодитойгоор тооцон ажиллах.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР